



## ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ ОНӨААТУГ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар A/30

Улаанбаатар хот

Г  
Байгууллагын ажиллагсадын хүүхдүүдэд  
урамшуулал олгох журам  
батлах тухай

Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.2, 1.10 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан, ажиллагсадын тэргүүний хүүхдүүдэд мөнгөн шагнал, урамшуулал, бэлэг олгох журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Журмыг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Санхүү, бүртгэлийн хэлтэс /С.Түмэн-Ундармаа/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.



УЛААНЧАЛАГДЫН ХҮҮХДҮҮДЭД  
Зорчигч тээврийн нэйтгэл” ОНӨААТҮГ-ын  
Захирлын 2019 оны дугаар сарын 13-ны  
өдрийн А/30 дугаар тушаалын хавсралт  
ОНОААТУТ

БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГСАДЫН ХҮҮХДҮҮДЭД  
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Зорилго: Ажилтан, ажиллагсдын хүүхдүүдийн суралцах, хөгжих эрхийг хангахад байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх, тэдний амжилтыг урамшуулан дэмжихэд оршино.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12.1.5 дугаар зүйлд “Хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам баталж, хэрэгжүүлэх”,

1.2. Боловсролын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3 дахь хэсэгт “хүүхдээ сургахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх....” зэргийг үндэслэл болгоно.

**Хоёр. Шагналын төрөл зүйл**

Олон улсын болон тив, дэлхийн чанартай уралдаан, улс хотын хэмжээнд зохион байгуулагдсан олимпиад, уралдаан, урлаг спортын тэмцээний ганцаарчилсан төрөлд шалгарсан хүүхдүүдийг шагнаж урамшуулна. Үүнд:

- 2.1. Олон улсын хэмжээний уралдаан, тэмцээнд оролцож
  - I байр эзэлсэн бол 100,000 төгрөг
  - II байр эзэлсэн бол 80,000 төгрөг
  - III байр эзэлсэн бол 60,000 төгрөг
- 2.2. Улсын хэмжээний уралдаан, тэмцээнд оролцож
  - I байр эзэлсэн бол 80,000 төгрөг
  - II байр эзэлсэн бол 60,000 төгрөг
  - III байр эзэлсэн бол 40,000 төгрөг
- 2.3. Нийслэлийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Нийслэлийн засаг даргын захирамж, Нийслэлийн боловсролын газрын даргын шийдвэр бүхий уралдаан, тэмцээнд оролцож
  - I байр эзэлсэн бол 70,000 төгрөг
  - II байр эзэлсэн бол 50,000 төгрөг
  - III байр эзэлсэн бол 30,000 төгрөгөөр тус тус урамшуулна.

### **Гурав: Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх**

3.1 Шагнал, урамшуулалд хамрагдах хүүхдүүдийн холбогдох материалыг тухайн жил бурийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн шагналын асуудал хариуцсан хүний нөөцийн менежерт хүлээлгэн өгнө.

3.2 Шагналын асуудал хариуцсан ажилтан материалыг нарийвчилан судалж, шагнагдагсдын талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, тушаалын төсөл боловсруулан холбогдох албан тушаалтнуудын саналыг авч нэгтгэлийн Захиралд танилцуулан шийдвэр гаргуулна.

3.3 Шийдвэрийн шатанд шаардагдах зардлыг шийдвэрийн дагуу холбогдох зардлаас гаргахыг Санхүү бүртгэлийн хэлтэс хариуцна.

3.4 Шагнагдсан хүүхдүүдийг байгууллагын сайт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

### **Дөрөв. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр ажилтнуудын хүүхдүүдэд бэлэг олгох**

4.1 Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр ажилтан, алба хаагчдын хүүхдүүдэд бэлэг олгоно.

4.2 “Бэлэг авах хүүхэд” гэдэгт байгууллагын ажилтнуудын нэг өрхийн 16 хүртэлх насны 1 хүүхэд хамаарна.

4.3 Ажилтан, алба хаагчдын хүүхдүүдийн судалгааг Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсээс урьдчилан гаргана.

### **Тав: Журмын хэрэгжилтэд хяналт тавих**

5.1 Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Дотоод хяналт шалгалтын хэлтэс хяналт тавьж ажиллана.

### **Зургаа: Бусад**

6.1 Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

6.2 Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарвал Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийвэрлэнэ.